

Огноо 2021.01.22

№ 21/соз.

Улаанбаатар

**2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД АУДИТ ХИЙХ
АУДИТЫН КОМПАНИЙГ СОНГОХ ТУХАЙ**

Компанийн тухайн хуулийн 65.6.2, 76.1.10, 81.43, 94.3, 94.4 дэх заалтууд, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20.1.6 дахь заалт, ТУЗ-ын Аудитын Хорооны санал дүгнэлт, 2021 оны 1 сарын 22-ний өдрийн цахим хэлбэрээр зохион байгуулсан ТУЗ-ын хурлын санал хураалтын дүнг үндэслэн, ТОГТООХ НЬ:

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Аудитын Хорооноос Санхүүгийн Зохицуулах Хороонд бүртгэлтэй эрх бүхий аудитын компаниудаас үнийн санал авч, харьцуулан дүгнэснээр ТУЗ-д Аудитын хорооноос санал болгосон Эс Эм Аудит ХХК-ийг уг асуудлаар санал эрхтэй гишүүдийн /Гүйцэтгэх Захирал О. Амартүвшин, нягтлан бодогч Д. Батсайхан уг асуудлаар саналын эрхгүй/ олонхийн саналаар баталсанаар, компанийн 2020 оны жилийн эцсийн тайланд аудит хийлгүүлэхийг зөвшөөрсүгэй.

Тус аудитын компанитай байгуулах гэрээг хавсралтаар баталсугай. Гэрээний хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэх Захирал О. Амартүвшинд даалгасугай.



ТУЗ-ИЙН ДАРГА

Г. ҮНЭНБАТ